

**Даяаршлын нөхцөлд Монгол хэрхэн  
Монголоороо үлдэх вэ**

*Доктор /PhD/, МУИС-ийн хүндэт профессор  
Д.Хүүхэнбаатар*

Монгол орны өнөөгийн хөгжлийн төвшин хөгжлийн чиг төлөвийг янз янзаар үзэх болжээ. Монгол зүүн коммунизмын социализмаас капитализмд шилжих гэж чадан ядан мөлхөж байгаа улс. Нэг хэсэг нь шилжилтийн шатанд байна гэхэд, нөгөө нь шилжилт дууссан гэж байна. Даяаршлын эцэг Монголчууд хоёр их гүрний хооронд найм дахь зуундаа өөрийгөө авч ирсэн сонин гайхамшигтай ард түмэн. Монголын юм бүхэн дэлхийд давтагдашгүй сонин гайхамшигийг дан ганц өрнөдийнхнөөр, суурьшмал соёл иргэншлийн үүднээс тайлбарлах нь учир дутагдалтай. Тэдний нэг хэвийн арга барилд болгоомжтой хандах, бүтээлчээр хэрэглэх нь чухал юм. Үүнээс болж, Монголын түүхийг гуйвуулж аугаа их Чингэсээ хараан зүхэж харгис, цуст алуурчин гэж газар дор ортол нь муулж саяхан болтол түүнээ баримталсаар иржээ. Харин ард түмэн тэгээгүй нандигнан шүтсээр байлаа. 1960-аад оноос арай аядуу өөрийн үзэл бодолтой болох хандлага тавигдсан юм. Гэвч үзэл суртлын хүлээсэнд баригдсаар байлаа. 1990-д оноос чөлөөтэй сайхан боллоо гэгцгээдэгч мэдэхгүйчүүдийн дураар дургихийн зууш болж, үгүйсгэл, хэтрүүлэг газар авлаа.

Би Монгол гэдгээ мэддэг үндэсний агуу их бахархалыг хүн бүрт яс маханд нь шингээх бэлчээрийн сонгодог мал аж ахуйгаа уламжлалт төрхөөр нь залгамжлан эрхлүүлэх л гол амин зорилт болоод байна. Хотжилт сууршилт бол нүүдлийн соёл иргэншлийн эсрэг аюулт гай гамшиг. Гэтэл хэзээ хаана ч байгаагүй нүүдлийн соёл аж төрөх ёсоо бусдын хараа нөлөөнд орж уусан устах аюулаас аврахын тулд даяаршил гэгчид Монголын нүүдлийн агуу их соёлыг хэрхэн авч үлдэх ухаанаа олох явдал туйлын чухал болоод байна. Бэлчээрийн мал аж ахуй байвал уламжлалт нүүдлийн соёл аж төрөх ёс оршин тогтносоор байх болно. Тэгэхдээ даяаршлын нөхцөлд нүүдэл-суурьшлын гэсэн хосолмол нийгэм оршин тогтнох нь гарцаагүй боллоо. Үүндээ тулж ирээд байгааг эрхэм монгол иргэд маань ухаарч байна уу Энэ чинь хэдийнээ эхлээд байгааг ч анзаарахгүй байгаа бололтой.

НҮБ-ын баримтанд дэлхийн 36 орны тухайд шилжилтийн үе эхэлсэн гэж тэмдэглэсэн бөгөөд түүний тоонд Монгол багтаж байгаа юм. Даяаршил Монголд эдийн засгийн дэвшлийг хангах, ядуурлыг бууруулж ард нийгмийн амьдралын түвшинг дээшлүүлэх зэрэг эерэг үр дагавар үзүүлэх нь дамжиггүй. Түүнийг бүтээлчээр зөв ашиглаж хэрэгжүүлэх нь Монголчуудын өөрсдөөс нь шалтгаална. Түүний зэрэгцээ сөрөг зүйл ч гарахгүй гэх газаргүй. Өнөөгийн хотжилт үүнийг батлах тод баримт. Даяаршлын үед Монгол орон улс төр эдийн засгийн бүрэн биеэ дааж хөл дээрээ тогтож чадсан өндөр боловсронгуй технологт суурилсан, бүтцийн хувьд зохистой аж үйлдвэр, хурдан өсөлттэй хөдөө аж ахуйтай, өөрийгөө тэтгэн дэвшигч эдийн засагтай, уламжлалт байгаль орчноо унаган төрхөөр нь хадгалсан эх түүх, соёл, зан заншил, шашнаа нандигнан хадгалж, цэцэглүүлсэн орон байхаар төсөөлүүлэн тодорхойлж болох юм. Өөрөөр хэлбэл нүүдэл, суурьшлийн харилцан тэтгэлцсэн өндөр хөгжсөн тийм сонгодог хэлбэр бий болох ёстой. Суурьшмал соёл, нүүдлийн соёл, аж төрөх ёсыг эзлэн "түрэмгийлэх явдал, хүчтэй боллоо" хэмээн сэтгэл түгших боллоо. Даяаршлийн үеийн мал аж ахуйд шинжлэх ухаан, орчин үеийн техник технологийг дээд зэргээр нэвтрүүлэх нь гарцаагүй, өөр арга зам байхгүй. Манай малчдад ч суурьшил, үйлдвэрлэлтэй зохицон хөгжих, түүнийгээ тэтгэн хөгжүүлэх салбар хэвээр авч өдий хүрсэн түүхэн туршлагатай хүмүүс хойшид ч тийм байх болно. Орос, Хятадын цөлмөгч капиталын үед ч буддын шашин дэлгэрч, 700-гаад сүм хийд байгуулж, шашинд бараг хүн ардаа толгой дараалан оруулсан цагт, ЗХУ-ын шийдвэрлэх тусламж, социалист нөхөрлөлийн орнуудын хамтын их эв нэгдэл бүхнийг мэдэж байхад ч бэлчээрийн мал аж ахуйгаа аван явж амин сүнс нь болсоор иржээ. Бэлчээр шүтсэн мал аж ахуйг эрхлэхэд 2000 орчим ажилбар гүйцэтгэдэг

гэж зарим эрдэмтэд үзсэн байх юм. Үүнтэй холбогдуулан зарим эрдэмтдийн үзэж байгаагаар гол зөрчил улс хоорондын биш, соёл иргэншлүүдийн хооронд болно гэдэг зөв байх. Ямар улс үндэстэн устаж үгүй болохыг хүсэх билээ.

Бидний даяаршил гээд байгаа их үйл явц нь чухамдаа даяарчлал бөгөөд хөгжилтэй хэдхэн том орнуудын хараат болно гэсэн үг.

Суурьшмал иргэншлийн тухайд бол тухай тухайн улс орондоо аж төрөхийн арга шүү дээ. Тэр дангаараа ерөөсөө байж чаддаггүй, хөршийгөө заавал эгээрч түшин харьцдаг. Энд үхэх, сэхэхийн ирэн дээр байдгийг Европчуудын түүх бэлээхэн гэрчилнэ. Энэ нь одоо тивчлэлээр, хөгжлийн давуугаар улс төр, эдийн засгийн дарамтлалаар явагдаж байгааг хэлэх юун. Бэлчээрийн мал аж ахуй нь хоцрогдлын шинж биш, харин ч сонгодог шинжтэй, мал нь өөрөө шимт ургамлыг сонгон идэж хэдийд гэдгээ онцгой мэдэрдэг бөгөөд бидэнд мах сүү, ноос ноолуур, арьс шир бусад түүхий эдийг бэлтгэж, анагаах онцгой чанартай эм, эмчилгээг нэгэн адил өгдөг. Тэгвэл суурьшмал соёлын ард хөгжил, соёлын ололт нээлт бүхэн нь өөрийгөө ба өрөөлийг хөнөөн мөхөөх аймшгийг байнга дагуулж явдагийг санахад илүүдэхгүй. Өнөөгийн АНУ, Английн Ирак, Хойд Солонгосын талаар явуулж байгаа бодлого, үйл ажиллагаа нь жижиг бага улсад тулган түрэмгийлсэн хэрэг мөн. Жижиг, бага орнууд өөрийгөө хамгаалж хөгжихийн тулд чадах бүхнээ түүний дотор цөмийн эрчим хүчийг эзэмшин нэвтрүүлэхийг эрмэлзэж байна. Үүнийг энх тайвныг хамгаалах нэрийн доор баялагт нь, тухайлбал АНУ Иракийн нефьтэнд шунаж байгаа хэрэг мөн гэж хэлж болно. Өнөөдрийн Монголыг харахад өргөн уудам нутагтаа таруу суудаг, ядууралд нэгэнт орсон байна. Хөрс шороондоо арвин баялагтай авч үйлдвэрлэлийн дэд бүтэц бүрэлдээгүй, боловсруулсан бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж алдагдлаа. Хөдөө аж ахуй, мал аж ахуй нь байгалийн эрхшээлд хэвээр аж ахуйн өөдлөх хандлага муу байна. Монголчууд бэлэнчлэх үзэлд автан том үйлдвэрлэл явуулах арга маягт суралцаагүй, боловсон хүчин ч үгүй байна. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бүтээгдэхүүн экспортлох, үйлдвэрүүдийг байгуулах хэрэгтэй байна. Тийм үйлдвэрүүдэд бордоо, ноос, арьс шир, нэхмэл, хүнс болоод машин засвар, хими технологи, нефть хими, электроникийн чиглэлээр хөгжүүлэх нь зөв гэсэн үзэл баримтлал зүйтэй. Ус, нар, салхины үүсвэрийг ашиглан эрчим хүчний үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд бүрэн бололцоотой бөгөөд хөдөө аж ахуйг эрчим хүчээр бүрэн хангах болно. Өөрсдөө хийж чадахаа хийж бүтээж импортыг хязгаарлах явдал зайлшгүй.

Үйлдвэрлэлийн бусад салбарт ч үүнд зохицон хурдацтай хөгжих болно. ХХ зууны сүүлийн арваад жилд эдийн засгийн уналт, тогтворжуулах, сэргээхийн төлөө тэмцлийн бэрх нарийн тэмцлийн жилүүд байлаа. Үүндээ алдаж оносон олон зүйл бийг хүлээх хэрэгтэй. ХХI зууны эхний жилүүдэд эдийн засгаа бие дааж хөгжүүлэх тэргүүлэх салбарыг барьж босгоход бас ч хоосонгүй, итгэл төрүүлж байна. Үүнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь зайлшгүй. 2010-2020 онуудад эдгээрийг хэрэгжүүлснээр улсын эдийн засгийн ашигтай бүтцийг бүрдүүлэх гэсэн үзэл баримтлал оргүй зүйл бишээ.

Өнөөдөр манай орны хувьд хүн хүчний чадавхтай нөөцийг бүрэлдүүлэх, үүний тулд боловсролд өөрчлөлт хийж амьдарч аж төрөх аргыг түлхүү оруулж амьдрах ухаантай хүмүүсийг бэлтгэхийг шаардаж байна.

Тийм нөөц бэлтгэгдээгүй байна. Боловсрол, шинжлэх ухааны салбарт сул анхаарч, зарим талаар орхигдуулж, төсөв хөрөнгөн дээр ч гар татдаг мөртлөө боловсрол тэргүүлэх салбар хэмээн уриалсаар байна. Хувийн олон дээд сургуулиуд байгуулагдан ажиллаж байгаа нь сайн боловч сургалт, төгсгөн гаргаж байгаа мэргэжилтний чанар сул, мөнгө олох гэсэн тал нь дийлж, цэвэр бизнесийн үйл ажиллагаа болж, хүн хүчний муу бүтээгдэхүүн бэлтгэдэг нэг уурхай болжээ. Суурьшмал соёл, иргэншил хүчтэй түрэн орж ирж байгаа нь нүүдэлч малчдыг олон мянган жил хуримтлуулж хүн төрөлхтний соёлд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж ирсэн нь алдагдах өв уламжлал мартагдах, уламжлалт мэдлэгийн хүрээг явцууруулах, сөрөг үр дагаварт хүргэж байна.

Уламжлалт мал аж ахуйг эрхэлэхэд дуу, хуур онцгой байр суурь эзэлдэг. Тойглох, хөөслөх, өөвлөх зэргээр ботго, хурга, тугал авахуулахдаа гийнгоолох, исгэрэх, дуулах, хуурдах зэрэг олон хэлбэрээр мал адгуустай дуу хуураар харьцдаг тийм улс үндэстэн дэлхийд байхгүй. Малын төрөл бүрийн өвчнийг анагаах бүхэл бүтэн мэдлэг ухаан ч монголчуудад нэн эртнээс уламжлалтай. Гэтэл хотууд хөдөөгөө мөлжиж, машин хөлөглөн ойр зуурын хэрэглээний зүйлээр мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нь хямдхан авч талийдаг байна. Ийм нөхцөл нь хөдөөнөөс хот руу нүүх их нүүдэл болж байгаагийн шалтгаан болж байна. Хөдөөд малчдаа, малаа авч үлдэхийн тулд өнөөгийн шинжлэх ухаан техникийн ололтыг эрчимтэй нэвтрүүлэх, усжуулах, тэдэнд цахилгаан эрчим хүчийг нэвтрүүлэх, хоршооллыг ухаалгаар дэмжиж хэрэгжүүлэх зэрэг нүүдэлч малчдын нийгмийн асуудал төр засгаас онцгой анхаарал тавих цаг болжээ.

Нүүдлийн соёл, иргэншлийг яг тэр чигээр нь авч үлдэнэ гэж байхгүй, хотын оюуны төвлөрлийг хөдөөд хандуулан шилжүүлэх хөдөлгөөнийг өрнүүлж, оюуны өндөр чадамжтай боловсролтой нүүдэлчид болох ёстой. Хөдөөд дутаад байгаа суурьшлын ололтыг зоригтой, шаргуу нэвтрүүлэх нь чухал байна.

Тэгж чадвал XXI зуунд хотоос хөдөө рүү хөврөх нүүдэл явагдах болно гэдэг санаа ортой юм. Нүүдлийн соёл, иргэншлийн асуудал нь улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолын амин чухал тал болж байдаг. VIII Богд Жавзандамба хутагт, Оросын Цагаан хаанд явуулсан бичигтээ их улсыг түшиглэн, харилцан туслалцаж, бага улсын ёсоор орших гэж уламжлалт гадаад бодлогоо тодорхойлсон байдаг.

Монголын түүхийг харахад их гүрнийг улс төрийн талаар түшиж, түүний хараат байдалтай байж газар нутаг, эдийн засаг, соёл, зан заншлаа бие даан хадгалж үлддэг онц сонин нарийн судлууштай зүйл ажиглагддаг. Манжид дагаж орсон нь зөв сонголт байж, Хятадад уусан устах аюулаас эрхшээл ивгээлийн орны хэлбэрээр гарч хойд, урд хил хязгаараа тогтоолгож, Манжийн үед Монголын соёл хүчтэй хөгжин, шарын шашин дэлгэрч хөгжлөө. Үүнийг хэрхэн тайлбарлах вэ?

XX зууны Монголын тусгаар тогтнол хаант Орос, ЗХУ-ыг түшиж, ивгээлийн хэлбэрээр нүүдлийн соёл, иргэншлээ авч үлдсэн.

Өнөө үеийн нүүдлийн соёл, аж төрөх аргаа авч үлдэхийн арга зам бол бүхнийг Монголчууд өөрсдөө барьж бүтээх л зөв зам. Үүндээ суурьшмал соёл иргэншлийг овсгоотой ашиглах арга чухал юм.

Монголчууд нүүдлийн соёл, аж төрөх аргаа авч үлдэх нь бүрэн бололцоотой гэсэн дүгнэлт хийж байна. Эх хэлээ нандигнан судлан хөгжүүлж, ариун тунгалаг байлгах үйлс бол мөн л даяаршлалаас үлдэх нэг том хөшүүрэг гэдгийг ямагт санаж эх хэлээ хамгаалах нь түүний салшгүй хэсэг, ариун тэмцэл мөн. Монголын соёл дэлхийд онцгой байр эзэлдэг, өөр хэнд ч дахин давтагдашгүй онцгой шинжтэй.

Монголын уртын дуу, морин хуур хөөмий, уран нугаралт, зээгт наамал гагцхан монголд л байна. Монголын хөх мэнгийг үе удамдаа дамжуулан удамшуулж ирсэний учрыг одоо хэн ч тайлж чадаагүй байна.

Газар лусыг тахиж аргадан зохицох замаар байгаль орчноо унаган төрхөөр нь авч үлдэж чадсан ганц орон бол монгол мөнөөсөө мөн.

Социализмын үед МАХН үндсэрхэх үзэл гэдэг үзэл суртлын сөрөг хүчинтэй тэмцсээр байсан ч уламжлалт монголын үндэсний соёл, зан заншил үлдсээр байж өдий хүрчээ. Бидний ялалт амжилт түүхэн үе бүхэнд хувьсан шинэчлэгдэж хөгжсөөр ирэхэд хамгийн гол нь Монголчуудын нэг санаа, эв нэгдэл байсан юм.

Олон нам болж сөргөлдөх, элдэв шашин дэлгэрүүлэх санаархал гарч байгаа нь монголчуудын чөлөөт уужуу сэтгэлгээнд саад болж буй сөрөг үзэгдэл ажиглагдсаар байна.

Даяаршлын нөхцөлд унаган сайхан төрх төлөв, онц содон нүүдлийн соёлоо хамгаалахын тулд эв санааны бат нэгдэлтэй байж, нэг хүн мэт зэрэглэн хөдөлж, нарийн чанд зохион байгуулалтанд зориглон орж, төр засгийн хүчтэй дэмжлэгийг хүлээсэн цагт айж эмээхийн зовлон арилах буйзаа.

Монгол хүн бүрт “Би монгол хүн ” гэсэн агуу итгэлийг төрүүлэх, мах цусанд нь шингээхийн тулд ихийг хийх шаардлагатай нь тодорхой. Монгол хэмээх удам судар, ариун цус, алтан ургаа мөнгө хөрөнгө, сониуч зангийн улмаас алдаж болохгүй гэдгийг хатуу баримталж ирсэн өвөг дээдсийнхээ сургаалийг бид бүхэн ялангуяа залуу үе маань үргэлж санаж яваасай гэж хэлэх нь ахмад бидний үүрэг гэж бодож байна.

Хот сууриныхан ялангуяа түүний залуу үеийнхэн монголоо, түүхээ тун бага мэддэг нь, бизнесийнхний зарим хэсгийн дотор ашигтай бол монголоо худалдахаас сийхгүй гэсэн хандлага аюул болж байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй. “Би монгол хүн” гэсэн үндэсний бахархалыг хүн бүрт шингээх хүндтэй бөгөөд туйлын нарийн алсын хараатай бодлого явуулах үйл, ажиллагааг шаардаж байна. Жинхэнэ монгол хүнээ төрүүлэе гэвэл эх түүхээ хүн бүрт мэдүүлэх явдал онцгой байр суурь эзэлнэ. Өнөөгийн монголчуудын эх түүхийн мэдлэг даан ч доогуур байгааг телевиз, радио, хэвлэлийн материалыг ажиглахад л мэдэгдэнэ. Эдүгээ бүх шатны сургуулиудын сургалтын программыг үндсээр нь өөрчилж мөрдөх, бас бүх нийтийг хамарсан түүхийн сургалтыг орон даяар явуулах нь зүйтэй. Эцсийн дүнд жинхэнэ монгол хүн хосгүй гайхамшигт нүүдлийн соёл иргэншлээ аврах эзэн нь юм шүү гэдгийг нийтээр мэдтүгэй.

### **“The sustainability of Mongolia in Globalization era”**

#### **The summary**

*By D.Khuukhenbaatar.*

The article about the place of Mongolia in globalization era. Problems of survival of Mongolian nation and transhumanism in the globalization have been discussed in this article. The transhumanism was, is, and should be essential part of our life. The maintainnace of our civilization is to obtain solid position in the world in new era.